




Бага боловсролын “Хүн ба байгаль”-ийн бие даан суралцах ажлын дэвтрийн хариултын хуудас

Бүлэг сэдэв: **Юмс үзэгдэл**

Дэд сэдэв: **Соронзын гайхамшиг**

Анги: **4 дүгээр анги**

СОРОНЗЫН ГАЙХАМШИГ: Соронзон туйл - 1

Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинжилгээ
1. Ойлгох түвшин	1 Доорх бичвэрийг уншаад үгсийг нөхөж бичээрэй. Та нар дэлхийг аварга том соронз гэдгийг мэдэх үү? Хэрэв чи зурагт үзүүлсэн шиг шулуун соронзыг уяад унжуулвал нэг байрандаа зогсно. Энэ нь соронз хоорондын харилцан үйлчлэлийн үр дүн юм. Соронзны нэг тал дэлхийн хойд туйл руу, нөгөө тал нь өмнөд туйл руу заана. Тэгвэл бид хойд туйл руу зааж байгаа талыг соронзын хойд туйл гээд N үсгээр, харин өмнөд туйл руу зааж байгаа талыг соронзын өмнөд туйл гээд S үсгээр тэмдэглэдэг.	
2. Ойлгох түвшин	2 Зурагт хоёр соронзын харилцан үйлчлэлийг харуулж байна. Хэрэв утсанд зүүж унжуулсан соронз сумны чиглэлийн дагуу хөдөлж байгаа бол өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.  Соронзны эсрэг туйлуудтаталцаж..... байна.  Соронзны ижил туйлуудтүлхэлцэж..... байна.	
3. Хэрэглэх түвшин	3 Доорх тохиолдолуудад хоёр соронз таталцах бол “ТАТ” эсвэл түлхэлцэх бол “ТҮЛХ” гэж тэмдэглээрэй.  ТҮЛХ  ТАТ  ТҮЛХ  ТҮЛХ  ТАТ  ТАТ  ТҮЛХ  ТАТ	

Бүлэг сэдэв: **Юмс үзэгдэл**

Дэд сэдэв: **Соронзын гайхамшиг**

Анги: **4 дүгээр анги**

СОРОНЗЫН ГАЙХАМШИГ: Соронзон туйл - 2

Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинжилгээ
1. Задлан шинжлэх	А) Хуваагдсан хэсгүүд ямар туйлтай байх вэ? Таамаглалаа бичээрэй. 1 2 1 2 1 2 1 2	

түвшин	<i>Сурагчид өөрсдийн таамаглалаар хойд, өмнөдийн аль нь байх вэ гэдгийг бичнэ.</i>	
2. Задлан шинжлэх	Б) Цэнхэр хэсгийг өөр нэгэн шулуун соронзод үйлчлүүлжээ. Үр дүнг дүгнэж бичээрэй. Та нарын таамаглалтай нийцэж байна уу?  Хоорондоо таталцаж байгаа учраас цэнхэр хэсгийн 2 гэсэн туйл нь өмнөд туйл байна.  Хоорондоо түлхэлцэж байгаа учраас цэнхэр хэсгийн 1 гэсэн туйл нь хойд туйл байна.	
3. Задлан шинжлэх	В) Бид цэнхэр хэсгийг ямар туйлуудтай болсныг мэдлээ. Тэгвэл цэнхэр болон улаан хэсгүүд хоорондоо хэрхэн үйлчилж байгааг дор үзүүлжээ. Үр дүнг дүгнэж бичээрэй. Та нарын таамаглалтай нийцэж байна уу?  Хоорондоо таталцаж байгаа учраас улаан хэсгийн 1 гэсэн туйл нь хойд туйл байна.  Хоорондоо түлхэлцэж байгаа учраас улаан хэсгийн 2 гэсэн туйл нь өмнөд туйл байна.	
4. Задлан шинжлэх	Г) Дээрх туршилтаас соронзыг хуваах үеийн туйлийн өөрчлөлтийн талаар өөрсдийн дүгнэлтийг бичээрэй. <i>Сурагчид туйлийг салгаж болдоггүй, соронз хуваагдахад хоёр жижиг соронз үүсдэг гэх мэтээр дүгнэж хэлсэн байна.</i>	

Бүлэг сэдэв: **Юмс үзэгдэл**

Дэд сэдэв: **Соронзон үйлчлэл**

Анги: **4 дүгээр анги**

СОРОНЗЫН ГАЙХАМШИГ: Соронзон хийцгээе

Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинжилгээ
1. Бүтээх түвшин	① Зааврын дагуу ажиллаад түр соронз хийцгээе. <i>Заавар тул хариулт байхгүй.</i>	
2. Задлан шинжлэх түвшин	② Хийсэн түр соронзоо ашиглан дараах асуултад хариулаарай. 1) Хадаасыг соронзын туйлуудтай үйлчлүүлж үзээд соронз болсон хадаасын туйлуудыг судлаарай. Хадаасны тав – Хадаасний үзүүр – 2) Хадаас соронзон шинж чанараа хэр удаан хадгалж байна вэ? <i>Хадаасны тав болон үзүүр эсрэг туйлуудтай болсон байна. Үргэлжлэх хугацаа нь сурагч болгонд өөр өөр байхыг анхаараарай.</i>	